



## **Шинжээчийн тайлан**

Байгууллагын нэр: **Хөдөө аж ахуйн их сургууль,  
Агроэкологийн сургууль**

Хөтөлбөрийн нэр: **Газар зохион байгуулалт**

Индекс: **D053211**

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц. Базарханд

Гишүүд: Д. Баттогтох

Н. Одсүрэн

Он сар өдөр: 2021-12-14

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Шалгуур 6: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яам
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
БХБЯ	Барилга, Хот Байгуулалтын Яам
БОЯ	Байгаль Орчны Яам
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрлэлийн Яам
ЗТЯ	Зам Тээврийн Яам
PEST	Political, Economic, Socio-cultural and Technological
STEER	Social, Technological, Economic, Environmental, and Political
SWOT	Strengths, Weaknesses, Opportunities, and Threats
ГЗБ	Газар зохион байгуулалт
АЭС	Агроэкологийн Сургууль
ГМТ	Газрын Менежментийн Тэнхим
ОХУ	Оросын Холбооны Улс
МГЗБХ	Монголын Газар Зохион Байгуулалтын Холбоо
MULS	Mongolian University of Life Sciences
IF	Impact Factor

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС) Mongolian University of Life Sciences (MULS)	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Газар зохион байгуулалт Land Management	
<b>Индекс</b>	D053211	
<b>Шинжээчид</b>	Багийн ахлагч: Ц.Базарханд /МУИС, Газарзүйн тэнхмийн дэд профессор/ Гишүүд: Д.Баттогтох /Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн захирал/ Д.Одсүрэн /СУИС-ийн СБЗГ-ийн дарга, дэд профессор/	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Ж.Мөнхбилэг БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	<b>2021.05.28</b>	Ажлын албаны захирал шинжээчийн багийг томиллох
	<b>2021.05.31</b>	Шинжээчтэй гэрээ байгуулан, өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгч, урьдчилсан үнэлгээг эхлүүлэх
	<b>2021.06.06</b>	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	<b>2021.06.08</b>	Мэргэжилтэн шинжээчдийн тодруулах асуултууд, үзэж танилцах нотлох баримтуудын жагсаалтыг сургуульд өгч, бэлтгэл хангуулах
	<b>2021.06.10-11</b>	Шинжээчид сургуульд танхимаар, цахимаар ажиллах
	<b>2021.12.13</b>	Шинжээчид үнэлгээний тайлан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	<b>2021.12.14</b>	Шинжээчийн үнэлгээний тайланг сургуульд илгээж, санал авах
	<b>2021.12.15</b>	Сургууль санал, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	<b>2021.12.15</b>	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэх
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд шинжээчийн үнэлгээний тайланг хэлэлцүүлэх
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан болон холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны Захирлын 2021 оны 02 сарын 10-ний өдрийн А/27 тушаал.	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1997 оноос 24 жилийн турш тасралтгүй Хөдөө аж ахуйн их сургууль болон түүний харьяа Дарханы салбар сургуульд 20 удаагийн төгсөлтөөр 2214 мэргэжилтэнг газрын харилцааны мэргэжилтэн бэлтгэн гаргасаар байна.

**Сургуулийн эрхэм зорилго:** “Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, амьдралын ухаан, байгаль орчны чиглэлээр шинжлэх ухаан, сургалт, үйлдвэрлэл, бизнес хосолсон бүс нутгийн тэргүүлэх их сургууль болно” гэсэн эрхэм зорилгын хүрээнд суралцагчдыг шинжлэх ухааны судалгааны ололтуудтай танилцуулан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглаж бие даасан судалгаа хийх дадалд сурган олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэхэд оршино.

### Зорилт:

1. Сургуулийн менежментийг төгөлдөржүүлэх
2. Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын нөхцөл дэх хөдөө аж ахуйн дээд боловсрол, шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх
3. Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг зах зээлийн эрэлт, хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх
4. Сургалтын агуулга, технологийг нийгмийн болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх
5. Судалгаа-сургалт-үйлдвэрлэлийн уялдаа холбоог бэхжүүлэх
6. Судлаач, баг нарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
7. Сургалт, судалгааны таатай орчин бүрдүүлж, оюутан суралцагч, багш нарын ажилтанд үзүүлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах
8. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

Тус хөтөлбөр нь 1997-1998 оны хичээлийн жилээс эхлэн элсэлт авч эхэлсэн. Мөн 1996 оны 03 сарын 09 өдөр Газар зохион байгуулалт: 621300, Газрын үнэлгээ: 621301, 2000 оны 5 сарын 18 өдөр Газар зохион байгуулалт: 621400, 2008 оны 12 сарын 9 өдөр Газрын кадастр, зураглал: 621400, 2014 оны 3 сарын 3 өдөр Газрын үнэлгээ, 2017 оны 06 сарын 25 өдөр Газар зохион байгуулалт: D 053211, Газрын кадастр: D 053211 зэрэгээр нэр индекс хөтөлбөрийн өөрчлөлт хийгдэж байсан.

**Хөтөлбөрийн зорилго:** Газрын нөөцийг шинжлэх ухааны үндэстэй судлах, төлөвлөх, зохион байгуулах, хамгаалах, газрын хил заагыг тогтоох, газрыг иргэдэд хуваарьлах, дахин хуваарьлах, газар ашиглалтын бүх төрлийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн хэрэгжилтэнд хяналт тавих, хуулийн хүрээнд газрын зөрчил маргааныг илрүүлэх, шийдвэрлэх ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Баримт нотолгоо:

- Салбарын яам, хэрэгжүүлэгч агентлаг, Нийслэл болон 21 аймгийн газрын зохион байгуулалтын алба, 360 гаруй сумдын даамал, үүнээс гадна байгаль орчин, газрын харилцааны чиглэлийн хувийн хэвшил, олон улсын байгууллага зэрэг олон талбарт газрын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавхи, нөөцийг нэмэгдүүлэх, газарзүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүргийг газрын харилцааны мэргэжилтнүүд гүйцэтгэдэг.
- Тасралтгүй өсөн нэмэгдэж буй мэргэжилтний эрэлт хэрэгцээг хангах зорилгоор мэргэжилтэн бэлтгэх, түүнд нийцүүлэн гаргасан батлагдсан мэргэжлийн хөтөлбөртэй танилцсан.
- Монгол улсын хэмжээнд газар зохион байгуулагч-инженер бэлтгэх хэрэгцээ, шаардлага болон техник технологийн хөгжил дэвшлээс хамааруулан хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг оновчтой тодорхойлжээ.
- 1997 оноос хойш ижил төстэй дотоод болон гадаадын их сургуулиудын хөтөлбөрийн судлан өөрийн мэргэжлийн хөтөлбөрөө тогтмол шинэчлэн сайжруулсаар ирсэн.
- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк
- Сургалтын хөтөлбөр
- Өөрийн үнэлгээний тайлан

##### Шалгуурыг хангасан байдал:

БҮРЭН ХАНГАСАН

##### Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн кредит, бүтэц агуулгыг сайжруулахад анхааран дотоодын ижил хөтөлбөр бүхий их дээд сургуулиудтай харьцуулснаас гадна гадаад орны ижил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулахад газарзүйн мэдээллийн систем, тандан судлалын хичээлээр бусад сургуулиудаас бага кредиттэй байгаа бөгөөд хөрс судлал, ургамал судлал, бэлчээр судлал, усан хангамж гэх мэт мэргэжлийн суурь хичээлийн багц цаг харьцангуй өндөр байна.

- Газрын менежментийн ур чадварын талаар хөтөлбөрт нэлээд дэлгэрэнгүй оруулж өгөх шаардлагатай. Газар зохион байгуулалтын мэргэжлийн бүрэлдэхүүн хэсэгт менежментийн асуудал томоохон байр суурийг эзэлдэг. Гэтэл энэ талаар уг хөтөлбөрт, мөн хүрэх үр дүнд ч тодорхой тусгасан зүйл байхгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Мэргэжлийн суурь хичээлийн цагийг багасгаж мэргэшүүлэх хичээлийн багц цагийг нэмэгдүүлэх боломжийг судлах
- Төгсөгчдөөс мэргэжлийн хичээлүүд нь ажлын байран дээр хэрэглэгдэхүйц мэдлэг өгч байгаа эсэх талаар болон шинээр орох ажлын байрны тооцоо судалгаа авах, үүнд үндэслэн хөтөлбөрийн хичээлийн агуулгыг тогтмол сайжруулж байх, элсэгч, төгсөгч нарын ажлын байрны эрэлт, хэрэгцээний асуудалд анхаарах
- Төгсөгчдөөс хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагын талаар судалгаа авч үр дүнг үндэслэн хөтөлбөрийг тогтвортой хөгжүүлэх

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### **Баримт нотолгоо:**

- Зорилго, хүрэх үр дүнгээ оновчтой тодорхойлсон, зорилгодоо хүрэх зорилт болон хүрэх үр дүнгээ уялдаа холбоотой загварчилсан.
- ХААИС, Агроэкологийн сургууль, Газар зохион байгуулалтын хөтөлбөрийн зорилго зорилтыг агуулгын нийцлээр тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилгоо сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан тодорхойлсон байдал
- Төгсөгчийн загварыг мэдлэг, чадвар, хандлага, нийгмийн чадамж, мэргэжлийн ерөнхий чадвар, мэргэжлийн суурь мэдлэг, технологийн мэдлэг, шинжлэх ухааны мэдлэг, цогц чадамж гэсэн чиглэлүүдэд авч үзсэн. Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал
- Сургалтын хөтөлбөр
- Өөрийн үнэлгээний тайлан

#### **Шалгуурыг хангасан байдал:**

##### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн зорилго, өөрчлөлтийн талаар нийтэд мэдээлдэг тухай хэсэгт сургууль, сурталчилгаа, ажил олгогчдыг татан оролцуулдаг талаар тайлангийн энэ хэсэгт тодорхой мэдээлэл өгөөгүй байна.
- Төгсөгчидтэй эргэх холбоотой ажилладаг талаар дурьдсан хэдий ч үүнээс ямар үр дүн гарсан, хэрхэн хамтарч ажилладаг талаар тодорхойгүй.

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчидтэй эргэх холбоотой үйл ажиллагаа явуулах, хамтран ажиллах арга барилаа сайжруулах, харилцаа холбоогүй тасралтгүй үргэлжлүүлэх
- Хөтөлбөрийн зорилго, өөрчлөлтийн талаар нийтэд нээлттэй мэдээллэх, мэргэжил сурталчлах, ажил олгогчдыг татан оролцуулах

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, чиг баримжаа нь эрэлт хэрэгцээнд нийцэж буй эсэхийг судлах

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигддаг эрх зүйн баримт бичгүүд болох Дээд боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын төлөөр баримтлах бодлого (2014-2021), Дээд боловсролын “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага” батлах тухай БСШУЯ-ны сайдын 2014 оны А/78 тушаал, БШУ-ны сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэлд тавигдах нийтлэг шаардлага”, 2021 он хүртэлх дээд боловсролын хөгжлийн бодлогын зорилт, үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх бодлого (2018) холбогдох бусад хууль тогтоомж, хөтөлбөр боловсруулах аргачлал, ХААИС-ийн захирлын 2014 оны А/228 дугаар тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн хорооны журам”, ХААИС-ийн захирлын 2014 оны А/427 дугаар тушаалаар батлагдсан “ХААИС-ийн бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам”, ХААИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын алба (СБЗА)-наас гаргасан “ХААИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн загвар” зэрэг баримт бичгүүдийг үндэслэл болгосон байна.
- ХААИС-ийн хөтөлбөрийн хорооны 2017 оны 08 сарын 25-ний өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан одоогийн баримталж буй сургалтын хөтөлбөр
- Бакалаврын сургалтын хөтөлбөрийн хороо байгуулан ажиллуулснаар 2017 онд хэрэгжүүлж эхэлсэн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын технологид тулгамдаж буй асуудлуудыг тодруулж сургалтын хөтөлбөрийн хүрээнд хичээлийн иж бүрдэл хийх зөвлөмж боловсруулж Агроэкологийн сургуулийн 2019 оны 09 сарын 02-ны өдрийн Эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний системийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Агроэкологийн сургуулийн “Заах арга зүйн зөвлөл”-ийг ажиллуулж байгаагаас гадна газрын мэргэжлийн байгууллагуудын саналыг хүлээн авч, багш нарын заах арга зүйг дээшлүүлэх, оюутны мэдлэг ур чадварыг сайжруулахын тулд тэнхимийн дотооддоо давтан сургалт, цахим хичээл бэлтгэх сургалтыг зохион байгуулсан байна.
- Батлагдсан хөтөлбөр, нэгдсэн төлөвлөгөөг тайланд оруулсан ба батлагдсан хичээлүүдийн хөтөлбөр
- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүтэц болох боловсролын суурь, мэргэшүүлэх хичээл болон дадлагын харьцаа нь БШУЯ-аас тавьсан шаардлагыг хангаж байна.
- Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичиг зохих журмын дагуу хийгдсэн, сайжруулалтад анхаарч ажилласан.
- Хөтөлбөрийн төлөвлөлтөд үр дүнд чиглэсэн байх, агуулга ур чадварын харилцан залгамж холбоог сайжруулах, сургалтын арга зүй болон үнэлгээний арга хэлбэрүүдийг баяжуулахад анхаарч ажилласан.



- Хөтөлбөрийн төлөвлөлтөөр өөрийн үнэлгээний тайлан гаргахдаа SWOT анализ хийсэн. Хөтөлбөрийн төлөвлөлтөөрөө олон улсын ижил төстэй хөтөлбөрүүдтэй нийцүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын аргазүйн орчин үеийн арга туршлагаудыг нэвтрүүлэх тал дээр анхаарсан.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр Хурлын тэмдэглэл

### **Шалгуурыг хангасан байдал:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Өөрийн үнэлгээний тайлангийн 21-р хуудаст хөтөлбөрөөр эзэмших чадварыг Хүснэгт 11-т тодорхойлсон хэдий ч үүнд газрын эрх зүйн зохицуулалтын чиглэлийн мэдлэгийг ямар хичээлээр олж авах тухай сургалтын хөтөлбөрт ороогүй байна.
- Мэргэжлийн хөтөлбөрийн сургалтыг тасралтгүй чанартай явуулах, чанарын хяналт удирдлагын систем сайн бүрэлдээгүй.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн оролцогч талуудын судалгааг хэвшүүлэх
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын заах арга зүйн орчин үеийн арга туршлагаудыг судлан өөрийн сургалтын хөтөлбөрт нутагшуулж болохуйц сайн туршлагаудыг нутагшуулж нэвтрүүлэх
- Сургалтын төлөвлөгөө, хичээл хоорондын уялдаа холбоо, агуулгыг тасралтгүй сайжруулах
- Төгсөгчдөөс хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага болон ажлын байрны олдоц, хүрэлцээ хангамжийн талаар судалгаа авч эзэмшээгүй үр чадварыг сургалтаар эзэмшүүлэх, төгсөгч, ажлын байрны эрэлт нийлүүлэлтийг үндэслэн элсэгчийн тоог төлөвлөх

#### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Газар зохион байгуулалт мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг MNS 5323-б:2004 стандарт, БШУЯ-ны баримталж буй бодлого, сургуулийн стратеги, эрхэм зорилготой уялдуулан Агроэкологийн сургууль нь 1997 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөг 2002 оноос эхлэн 2007, 2012, 2015, 2017 онуудад сайжруулсан байна.
- 2017 онд сургалтын төлөвлөгөөг дотоодын БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдэн (2015), өгсөн зөвлөмжийн дагуу хөтөлбөрийн оролцогч талуудын санал хүсэлтэд үндэслэн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлтийг хийж сайжруулсан.

- Хөтөлбөрийн эзэмшүүлэх мэдлэг, ур чадвар хандлагыг сургалтын төлөвлөгөөний хэмжээнд болон хичээлийн хэлбэр, нэр төрөл, хичээл хоорондын залгамж агуулгаар судалж холбосон.
- Сургалтын төлөвлөгөөнд сургалтын дадлагын кредит цагийг 6 кредит болгон нэмэгдүүлснээр суралцагчдын бие даан суралцах чадвар болон онол практикийн зохистой харьцаанд анхаарсан байна.
- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Өөрийн үнэлгээний тайлан

### **Шалгуурыг хангасан байдал:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар танхимын сургалтаар олж авсан мэдлэгээ ажлын байранд бага ашиглаж байгаа гэсэн дүн гарсан байна. Иймд шинээр бэлтгэгдэж буй ажилтнуудад багаар ажиллах чадвар, санаачлагатай, бүтээлч, бие даах чадвартай байх тухай ойлголтыг олгох нь цаашид мэргэжлээрээ өсөн бойжиход зайлшгүй анхаарах асуудал юм. Иймд энэ чиглэлийн мэдлэг олгох талаар хөтөлбөрт тусгагдсан зүйл хараахан байхгүй байна. Энэ чиглэлийг хөтөлбөрт тусгайлан тусгахгүй байж болох ч хичээлийн явц сэдэв болгонтой холбогдуулж уг чадварыг оюутанд эзэмшүүлэхэд багшийн мэдлэг, ур чадвар сайжруулах хэрэгтэй.

#### **Зөвлөмж:**

- Суралцагчийн сурах идэвх болон орчин үеийн арга барилд суурилан сургалтыг явуулах, хос хөтөлбөрөөр суралцах бололцоог сайжруулах
- Цаг үеийн байдал болон салбарын өөрчлөлтийн чиг хандлагын дагуу хөтөлбөрийн шинэчлэлийг цаг алдалгүй хийж байх

### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

#### **Баримт нотолгоо:**

- Сургалтын аргазүйг Монгол улсад мөрдөгдөж буй стандарт шалгуурын дагуу боловсруулдаг. Өмнө нь хэрэглэгдэж байсан хөтөлбөрүүд багшийн үйл ажиллагаа голлосон, онолд суурилсан байсан бол шинэ хөтөлбөрт суралцагчийн идэвхтэй үйл ажиллагаа, оюутан төвтэй хөтөлбөрийн зорилгод нийцсэн цогц чадамжид суурилсан байна.
- Сургалтын аргазүйд шинжилгээ хийснээр тохиолдолд суурилсан сургалтын аргуудыг өргөн хэрэглэх, сургалтын дата, баазаа сайжруулах, сургалтад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дата, програм хангамж ашиглах, оюутны суралцах идэвхийг нэмэгдүүлэх, сургалтад цахим технологийг түлхүү ашиглах шаардлагатай байгааг судалсан байна.

- Сургалтын аргагүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал
- Өөрийн үнэлгээний тайлан

### **Шалгуурыг хангасан байдал:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтад ашиглаж буй мэргэжлийн програмын лицензийн эрхийн хугацаа дууссан байна.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын үйл ажиллагаанд тохиолдолд суурилсан сургалтын аргуудыг өргөн хэрэглэх
- Сургалтын орчин үеийн лаборатори, дадлагын бааз, ажлын байранд суурилан явуулах
- Мэдлэг ур чадварыг харилцан уялдаатайгаар тасралтгүй олгох
- Дадлага семинарын хичээлийн тодорхой тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх талаас нь харилцан ярилцаж, оюутнуудаар шийдвэр гаргуулах, шийдвэрийн зөв хариултыг жишээн дээр тайлбарлах замаар чиглүүлсэн сургалтын аргыг хэрэглэж хэвших
- Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн програмуудыг лицензийн эрхтэй ашиглах

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- ХААИС-ийн захирлын 2016 оны 07 сарын 28-ны А/153 тоот тушаалын дагуу оюутны эзэмшсэн мэдлэг, чадварын түвшинг явцын болон хөндлөнгийн үнэлгээгээр үнэлдэг.
- Суралцагчдыг тасралтгүй хөгжүүлэх зорилгоор Рубрик аргыг үнэлгээнд ашигласан.
- Сургалтын үйл ажиллагаа, сурагчийн үнэлгээ ил, тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байна.
- Явцын болон төгсөлтийн шалгалтыг суралцагчийн ил тод, найдвартай, шударга эрх тэгш үнэлэх журмыг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд тухайн оюутныг шударга бус үнэлсэн талаар санал гомдлоо дараа улирлын эхний сард өргөдөл гарган шийдвэрлүүлэх, багш суралцагчийн дүнг шалгалт авсан өдрөөс хойш 5 хоногт багтаан сургуулийн сургалтын системд байршуулах, оюутан өөрийн дүнгийн мэдээллийг тухай бүрт харах боломжтой, удирдлага мэдээллийн системээс багшийн үнэлгээг сургуулийн хэмжээнд дээд, доод хязгаартай харьцуулан бодит байдалд үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой байна.
- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м/

## **Шалгуурыг хангасан байдал:**

### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчдын амжилт чанарыг үзвэл сүүлийн 5 жилд голч дүн өссөн бөгөөд дундаж голч дүн 2.51, сурлагын амжилт 89.8%, чанар 42.0% байна.
- Хичээл нэг бүрийн үнэлгээ болон шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд шинжилгээ хийгээгүй.

#### **Зөвлөмж:**

- Суралцагчдын амжилт чанарыг сайжруулах тал дээр үе шаттай арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлэх
- Сургалтын төлөвлөгөө болон хичээлүүдийн агуулгыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийх
- Хичээл нэг бүрийн үнэлгээ болон шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд шинжилгээ хийх
- Оюутны сурах идэвх болон орчин үеийн арга технологид суурилан сургалтыг явуулах
- Үйлдвэрлэлийн дадлагыг үр дүнтэй өргөн цар хүрээтэй, мэргэжлийн практик дадлага олж авах үүднээс хяналтыг сайжруулж удирдагчтай эргэх холбоотой ажиллах
- Мэргэжилтэн, төгсөгчдөөс суралцагчдаас авч буй санал асуулгыг тогтмол авч хэвших, түүнд үнэлэлт, дүгнэлт хийж, арга хэмжээ авах

### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Газар зохион байгуулалтын хөтөлбөрийн сургалтад Агроэкологийн сургуулийн лекцийн 3 танхим, семинарын 8, сургалт судалгааны чиглэлийн 6 лаборатори ашиглагдаж байгаагаас 5 лаборатори нь мэргэжлийн чиглэлээр 1 лаборатори нь хөрс судлалын чиглэлээр ашиглагддаг. Хөтөлбөрийн сургалтад хичээл зааж буй багшид ногдох өрөө тасалгааны талбай 7.08 м<sup>2</sup>, бакалаврын нэг оюутанд ногдох хичээлийн танхимын талбай 9 м<sup>2</sup> болж нэмэгдсэн байна.
- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Хөтөлбөрийн багш нар болон хичээлийн танхимууд, онлайн болон зайны сургалт, танхимын сургалт явуулах бололцоог бүрэн хангасан, лабораториудыг 2018 онд Газар ашиглалт, төлөвлөлтийн лабораторид 6.0 сая төгрөг, 2019 онд Геодезийн кобенитыг 15.0 сая төгрөгийг санхүүжилтээр засварласан байна.
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

## **Шалгуурыг хангасан байдал:**

### **ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Тус хөтөлбөрт суралцаж буй нийт 127 оюутнуудаас анги танхимын хүрэлцээ хангамжийн талаар судалгаа авахад 19.6% маш сайн, 48.28% сайн, 27.56% дунд, 2.87% муу гэж үнэлсэн бол сургалтын хэрэглэгдэхүүний сэтгэл ханамжийн судалгаагаар 20.4% маш сайн, 53.15% сайн, 22.8% дунд, 3.34% муу гэж үнэлсэн байна. Суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд гарсан сайжруулах шаардлагатай зүйлсэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Сургалтын орчин нөхцөл, бие даалтын кабинетийн хангамж, оюутны эрүүл аюулгүй сурч боловсрох боломжийг тасралтгүй нэмэгдүүлэх
- Газар зохион байгуулалтын мэргэжлийн ховор болон суралцагчдын дунд эрэлт хэрэгцээ өндөр сурах бичиг, ном, материалын нарийвчилсан судалгаа авах, хүрэлцэхгүй байгаа эсвэл хоногоор өгдөггүй зэрэг цөөн ширхэгээр байдаг сурах бичиг, ном, материалыг судалгаанд үндэслэн нэмэгдүүлэх
- Техник технологийн хүчин чадал үзүүлэлтийг сайжруулах, компьютерийн чиглэлийн мэргэжлийн зарим лабораториудад компьютерийг шинэчлэх

#### **Шаардлага:**

- Суралцагчдын 30 орчим хувь нь анги танхимын хүрэлцээ хангамж болон сургалтын хэрэглэгдэхүүнийг дунд болон муу гэж үнэлсэн. Нэг оюутанд ногдох анги танхимын талбайн хэмжээг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 74 дүгээр тушаалын хавсралтын дагуу нэг оюутанд ногдох мэргэжлийн ном, сурах бичгийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Тус сургуулийн сургалтын орчныг үе шаттай, тогтвортой сайжруулж ирсэн байна.
- Тус хөтөлбөрт 2003 оноос Геомэдээллийн 2 лабораторийг ашиглаж байгаа бол 2015 оноос Бэлчээрийн газрын судалгааны лаборатори, Газар ашиглалт, төлөвлөлтийн лаборатори, Газрын үнэлгээ мониторингийн лабораториудыг тус тус сургалтад ашиглаж байна.
- Хөтөлбөрт газарзүйн мэдээллийн системийн ArcGIS, QGIS, ENVI, Erdas Imagine, AutoCAD, Монгол улсын газрын нэгдмэл сангийн тоо бүртгэлийн Ланд Менежерийн веб хувилбар, бэлчээрийн мониторингийн Sample Point зэрэг програмуудыг албан ёсны гэрээт болон албан ёсны зөвшөөрөлгүй хувилбаруудыг ашигладаг байна.
- Газар зохион байгуулалтын хөтөлбөрийн хичээлүүдийн хүрээнд тус бүрээр үзүүлэн, тараах материал .pdf, .doc, .xls, .swf, .exe, mp4 үзүүлэн гарын авлага, цахим сургалтад GOOGLE CLASSROOM ашигладаг байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

## **Шалгуурыг хангасан байдал:**

### **ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын хэрэглэгдэхүүний сэтгэл ханамжийн судалгаагаар 20.4% маш сайн, 53.15% сайн, 22.8% дунд, 3.34% муу гэж үнэлсэн байна.
- Мэргэжлийн програмууд лицензийн эрхгүй байна.
- Лабораторид ашиглагдаж буй компьютерийн ажиллагаа, мэргэжлийн програм дээр ажиллахад шаардлага хангахуйц хүчин чадалтай эсэхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Сургалтын хэрэглэгдэхүүнд суралцагчдын 25% сэтгэл ханамжгүй байгаа тул цаашид анхаарч ажиллах
- Багаж тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг байнга хийж байх
- Хичээлд хэрэглэгддэг нээлттэй эх үүсвэрийн цахим хичээл, цахим номын сан, эрдэм шинжилгээний онлайн эх сурвалжуудын талаар мэдээллийг суралцагчдад тогтмол хүргэж байх
- Програм хангамжийн лицензийн асуудалд анхаарах, нээлттэй эх үүсвэрийн болон албан ёсны эрхтэй програмуудыг ашиглах боломжийг нэмэгдүүлэх

#### **Шаардлага:**

- Албан ёсны лицензийн эрхтэй мэргэжлийн програмуудыг ашиглах шаардлагатай.
- Зарим шаардлага хангахгүй, хүчин чадал хүрэлцэхгүй, мэргэжлийн програм дээр ажиллахад хүндрэлтэй компьютерүүд болон эд ангийг сольж шинэчлэх шаардлагатай.

### **3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- ХААИС-ийн номын санд 170485 ном сурах бичгийн 829 цахим хэлбэрээр, 421 докторын диссертацийн 191 цахим хэлбэрээр, 1669 магистрын ажлын 804 цахим хэлбэрээр, 848 бакалаврын төгсөлтийн ажил 254 цахим хэлбэрээр, 1574 автореферат 1128 цахим хэлбэрт орсон байна. Түүнээс гадна хатуу дискт бичигдсэн ном 1128, докторын ажил 191, магистрын ажил 1006 байна.
- Номын сангийн баяжуулалт жил бүр хийгддэг бөгөөд цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх тал дээр тогтмол анхаарч ажилласан байна.
- Номын сангийн Lib4U програм ашиглан улсын томоохон номын сангууд болон их дээд сургуулиудын цахим каталоогоос хайлт хийх мөн томоохон номын цахим сайтуудаас хайлт хийх нөхцөл бүрдсэн байна.
- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

## **Шалгуурыг хангасан байдал:**

### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Суруулийн номын сангийн хүрэлцээ хангамжийн судалгаанаас үзэхэд 37% сэтгэл ханамжгүй гэж үнэлсэн байна.

#### **Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээний бүтээлийг бүрэн цахимжуулах
- Ном, сурах бичгийн хүрэлцээ хангамжийн судалгааг нарийвчлан хийх, цөөн байдаг, хоногоор олгодоггүй, суралцагчдын дунд хүрэлцээ муу байдаг ном сурах бичгийг нэмэгдүүлэх
- Гадаад болон монгол хэлээр хэвлэгдсэн ном, материал, мэдээллийг тогтмол баяжуулах бодлого баримтлах

### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

#### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежмент, маркетингийг хэрэгжүүлнэ.

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- ХААИС-ийн захирлын 2014 оны А/202 дугаар тушаалаар Агроэкологийн сургуулийг 4 тэнхимтэй болгосны дагуу Газрын менежментийн тэнхим болгон Газар зохион байгуулалтын хөтөлбөр мэргэжилтэн бэлтгэж ирсэн байна.
- Судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд ХААИС-ийн захирлын 2013 оны 404 дүгээр тушаалаар ГЗБ-ын профессорын багийг байгуулсан байна.
- Хөтөлбөрөөр суралцагсдын гомдол саналыг сургалтын албаны дэргэд байршуулсан санал хүсэлтийн хайрцгаар тогтмол авдаг.
- ГЗБ-ийн хөтөлбөрийн 2017-2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөг боловсруулж, МХХ-ы 2018 оны 05 сарын 23-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулан мөрдөж байна.
- Тус хөтөлбөрийн баг сургуулийн ерөнхий үйл ажиллагаа стратеги зорилтын хүрээнд ХААИС, АЭС, тэнхим, багш гэсэн шатлалтайгаар жил бүр ажлаа төлөвлөн гүйцэтгэлийг багш өөрийн үнэлгээний тайлан, цагийн гүйцэтгэлээр, тэнхим хагас ба бүтэн жилийн тайлангаар, бүрэлдэхүүн сургууль хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг менежер буюу захирал үр дүнгийн гэрээний биелэлтээр тайлагнадаг. Тайлангийн ерөнхий үнэлгээг АЭС-ийн захирлын үр дүнгийн гэрээ хэлбэрээр ХААИС-ийн захирлын зөвлөлөөр хэлэлцэн үнэлгээ өгдөг бөгөөд сүүлийн 3 жилд үр дүнгийн гэрээний биелэлт 2018 онд 88%, 2019 онд 91%, 2020 онд 95%-ийн биелэлттэй үнэлэгдэж ирсэн байна.
- Хөтөлбөрийн удирдлага сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулах нөөцийг оновчтой хуваарилж, стратеги менежментийг зөв хуваарилж ирсэн байна. ХААИС 2006-2007 оны хичээлийн жилээс цахим их сургуульд зориулагдсан “Uniface” програм хангамжийг, 2015-2016 оны хичээлийн жилээс “ULMS” буюу University Learning Management System–ийг хэрэглэж байгаад 2020 оноос өөрийн сургуулийн мэдээллийн багийн боловсруулсан ISLS удирдлага мэдээллийн системийг

ашиглаж байгаа нь хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангах боломжийг олгож байна.

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

### **Шалгуурыг хангасан байдал:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Удирдлага, стратеги, сургалттай холбоотой төлөвлөлт, бодлого тодорхойлохдоо цаашдаа олон улсын чиг хандлагад нийцүүлэхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг зах зээлийн эрэлт, хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх
- Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн уялдаа холбоог бэхжүүлэх
- Сургалт, судалгааны таатай орчин бүрдүүлж, оюутан суралцагч, баг ажилтанд үзүүлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах
- Гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Сургалтын албаны програм хангамжийн хувьд багш системдээ даалгавар, бие даалт байршуулах, оюутан цахим системээрээ дамжуулан хэвлэмэл бус байдлаар бие даалт, даалгавраа байршуулах боломжоор хангах

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Газрын менежментийн тэнхим нь 3 улсын 4 их сургууль, 1 академитай хамтын ажиллагааны хүрээнд оюутан солилцох, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах мөн хос хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажилладаг.
- ГЗБ-ын хөтөлбөр 2+2 хөтөлбөрийн хүрээнд 2016-2019 оны байдлаар 13 оюутан хамтран ажилладаг сургуулиудыг төгссөн байна.
- ГМТ нь газрын харилцааны мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагууд мэргэжлийн компаниудтай хамтран сургалт зохион байгуулах, хурал, зөвлөгөөн хийх зэргээр нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг.
- Төгсөгчдийн холбоог 2017 онд Газрын харилцааны мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн 20 жилийн ойг тохиолдуулан тэмдэглэн өнгөрүүлэх нэгдсэн хурлын үеэр байгуулсан ба төгсөгчдийн холбоо гэсэн фэйсбүүк группыг байнга ажиллуулан мэргэжил дээшлүүлэх, ажлын байрны зар гэх мэт мэдээллийг тогтмол хүргэж ажилладаг.



- 2017-2020 оны хугацаанд нийт 48 төгсөгч магистрын хөтөлбөрт, 11 төгсөгч докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж байна.
- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

#### **Шалгуурыг хангасан байдал:**

БҮРЭН ХАНГАСАН

#### **Анхаарах асуудал:**

- Ерөнхий мэдлэгийн хичээлд багш нараас гадна төрийн, хувийн, эрдэм шинжилгээний байгууллагуудын мэргэжилтэн, инженер, судлаач нараар хичээл заалгах, мэдлэг мэдээлэл танилцуулах хэрэгтэй байна.

#### **Зөвлөмж:**

- Судалгааны байгууллагуудад судлаач оюутнуудыг дадлагажуулах боломж нээж өгөх
- Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад хамтын ажиллагаа, хамтарсан төсөл, урт богино хугацааны сургалт зэргийн тасралтгүй хөгжих боломжийг хадгалан үлдэх, цаашид хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлого боловсруулах

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Баримт нотолгоо:**

- ГЗБ-ын хөтөлбөрийн төсөв, ХААИС-ийн нэгдсэн төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч АЭС-ийн төсвөөс санхүүждэг.
- Тус хөтөлбөрөөр суралцдаг нэг оюутанд зарцуулах өртөг зардлын тооцоо 2020 оны хичээлийн жилд 2708.2 мян төгрөг болж хугацааны эхэн үеийнхээс 29.28 хувиар нэмэгдсэн байна.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэл өөрчлөлтөд зориулсан төсөв жил бүр өсч байгаагаас гадна нийт төсвийн дийлэнх хувийг сургалттай холбоотой шууд ба шууд бус зардал эзэлж байна.
- Төсөл хөтөлбөрийн санхүүжилт АЭС-ийн хэмжээнд 2016 оноос 2019 онд 13 дахин өссөн бол 2020 онд хугацааны эхэнтэй харьцуулахад 10 дахин өссөн үзүүлэлт гарч байна. Сургалт судалгааны лабораториудын орлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулагддаг байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

#### **Шалгуурыг хангасан байдал:**

БҮРЭН ХАНГАСАН

#### **Анхаарах асуудал:**

- Шууд бус зардал жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь зах зээлийн үнийн өсөлттэй холбоотой тул зардал төсөвлөхдөө зах зээлийн үнийн мэдээнд тулгуурлан уян хатан төлөвлөлт хийхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Удирдлагын зүгээс санхүүжилтийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллах
- Зардал, санхүүжилт нэмэгдэхийн хэрээр чанарын үзүүлэлт сайжирч байгаа эсэхэд хяналт тавьж, үр дүнгээ хамт олноороо хэлэлцдэг байх

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Баримт нотолгоо:**

- Хөдөлмөрийн зах зээлийг тандах судалгааг 4 төрлөөр ажил олгогчдын судалгаа, төгсөгчдийг мөшгих судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын судалгаа, ажлын байрын эрэлт буюу сонин хэвлэл, цахим группын судалгаагаар тус тус хийдэг.
- Газар зохион байгуулалт мэргэжлийн хөтөлбөрийн хүрээнд зорилтот зах зээлд чиглэсэн төлөвлөгөөт арга хэмжээ бүхий “ХААИС-Амьдралын их сургууль”, “Элсэлт”, “Эрдэмд хөтлөхүй”, “MULS-Sustainable Development”, “ХААИС-ийн баялаг” дэд хөтөлбөрүүдийг багтаадаг.
- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

#### **Шалгуурыг хангасан байдал:**

##### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Цаг үеэс хамааран сүүлийн 2 жилд танхимаар болон олон хүн цуглуулан мэргэжил сурталчлах боломж хомс байсан бөгөөд тухайн хугацаанд мэргэжил сурталчлах, таниулах ажлыг хэрхэн зохион байгуулсан талаар өөрийн үнэлгээний тайланд тусгагдаагүй. Зорилтод зах зээлд чиглэсэн бие даасан маркетингийн хөтөлбөргүй.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа сул

#### **Зөвлөмж:**

- Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан хөтөлбөрийг таниулан сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг нийтэд хүртээлтэй нээлттэй цахим хэрэгсэл ашиглан зохион байгуулах, таниулах, тусгайлан мэргэжил сонголтын талаар ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийнханд хөтөлбөрийн талаар мэдлэг, мэдээлэл авах боломжийг хангах
- Мэргэжил таниулах, сурталчлахад төгсөгчид болон төгсөгчдийн холбоог татан оролцуулах

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

### **Баримт нотолгоо:**

- 2021 оны 05 сарын байдлаар Газрын менежментийн тэнхимийн 5 багш 11 гарын авлага “Цахим ном цаглашгүй үйлс аян”-д нэгдэн байршуулсан.
- ХААИС [www.muls.mn](http://www.muls.mn), АЭС [www.agroecology.muls.mn](http://www.agroecology.muls.mn) хаягаар тогтмол мэдээллийг хүргэн ажилладаг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

### **Шалгуурыг хангасан байдал:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн вэб хариуцсан мэргэжилтэн дутагдалтайн улмаас вэбийн өнөөгийн үйл ажиллагааны тогтвортой байдал, мэдээллийг тасралтгүй шинэчлэх тал дээр сул.

#### **Зөвлөмж:**

- Сургуулийн вэбсайтын мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчлэх, оюутан сурагчдыг өөр хэрэгтэй мэдээ мэдээлэл авах боломжийг үргэлжлүүлэн хангаж ажиллах
- Вэб хөгжүүлэлтийг тасралтгүй хийж байх

#### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

### **Баримт нотолгоо:**

- Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны Сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, ХААИС-ийн Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг үндэслэн оюутан элсүүлдэг.
- ХААИС-ийн оюутан элсүүлэх журмын дагуу Газар зохион байгуулалт хөтөлбөрөөр суралцагч нь Математик, Газарзүйн хичээлийн аль нэгээр 480-аас дээш оноо авсан иргэнийг элсүүлдэг.
- Олон улсын болон улсын албан ёсны математик, газарзүйн хичээлийн олимпиадад 1-10 дугаар байр, бүс нутаг, аймгийн хэмжээний олимпиадад 1-5 дугаар байр, урлаг спортын олон улс, улсын хэмжээний уралдаан тэмцээнд 1-3 дугаар байр, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад элсэн суралцах давуу эрх олгодог.
- Элсэлтийн дүрэм журмыг мөрдөн ажиллахын зэрэгцээ орон нутгийн захиалгыг элсэлтийн бодлогодоо тусгадаг.
- Элсэлтийн үйл ажиллагааны хүрээнд “Мэргэжил миний ирээдүй”, “Элсэлтийн нээлттэй мэдээлэл”, “ХААИС-ийн элч оюутан” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.
- Уг хөтөлбөрөөр 2016-2020 оны хооронд 441 оюутан элссэн ба элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо 5 жилийн хугацаанд жигд үзүүлэлттэй (дундаж оноо 510) байна. Гэвч элсэгчдийн тоо 2016 оныг 2019 онтой харьцуулахад 3 дахин буурсан. Элсэгчдийн тоо буурсан нь ерөнхий боловсролын

сургууль төгсөгчдийн тооноос шууд хамааралтай бөгөөд 2020 оноос бага зэрэг өсөх хандлагатай болсон байна.

- Элсэлтийн үйл ажиллагааны хүрээнд “Мэргэжил миний ирээдүй”, “Элсэлтийн нээлттэй мэдээлэл”, “ХААИС-ийн элч оюутан” хөтөлбөрүүд нь бусад сургуулиудад хэрэгжүүлж болох сайн туршлага байна.
- Тус хөтөлбөрөөр гадаад оюутан суралцдаггүй.

#### **Шинжээчийн үнэлгээ:**

##### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Цаашид элсэлтийн сурталчилгааг хүртээмжтэй хийх, хөтөлбөрийн нэр хүндийг дээшлүүлэх чиглэлээр багц ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, элсэлтийг тогтвортой барих бодлогыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

#### **Зөвлөмж:**

- Суралцагч элсүүлэхдээ нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан элсэлтийн тоог тогтоох асуудлыг авч үзэх
- Элсэлтийн мэдээлэл, хөнгөлөлттэй суралцах боломжийг нийтэд илүү хүртээмжтэй хүргэх арга хэрэгслийг турших

#### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Шинэ элсэгчдэд зориулсан гарын авлагыг хэвлэн түүнд сургалтын үйл ажиллагаатай холбоотой журмууд, оюутанд чиглэсэн үйлчилгээ, оюутны хөгжил хөтөлбөр зэргийг багтаасан. Энэхүү гарын авлагын агуулгыг жил бүр шинэчлэн сайжруулдаг.
- ХААИС-ийн оюутнуудад зориулсан зөвлөн туслах үйлчилгээний бодлого төлөвлөлтийн зураглалыг гаргасан. Үүнд оюутны төлөвшил, хүмүүжил, хувь хүний хөгжил, амжилттай суралцах үйл явцыг бүхэлд нь хамардаг. “Оюутны хөгжил хөтөлбөр”, “ХААН кампус”, “Экологийн цэвэр орчин” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр “Оюутны хөгжил төв”, “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-үүд ажилладаг. Эдгээр алба нэгжүүд нь 6 чиглэл (сургалтын үйлчилгээ, нийгмийн үйлчилгээ, санхүүгийн дэмжлэг, зөвлөгөө өгөх, хувь хүний хөгжлийг дэмжих, мэдээ мэдээллийн үйлчилгээ)-ээр 24 төрлийн үйлчилгээг тогтмол үзүүлдэг.
- 2019 онд ХААИС-ийн оюутны хөгжлийн загвар, чадамжийн хүрээг тодорхойлж 4 чадамж (мэдлэг оюуны, ногоон хөгжлийн, хувь хүний хөгжлийн, нийгмийн оролцооны чадамжууд), 16 дэд чадварыг эзэмшсэн байхаар төлөвлөжээ.
- Оюутныг суралцах үйл ажиллагаанд туслах, зөвлөгөө өгөх үүрэгтэй зөвлөх багш, сургалтын менежер, туслах ажилтан арга зүйч, байрны багш, эмчийн үйлчилгээний чанарын үзүүлэлтийг үнэлэх оюутны сэтгэл ханамжийн судалгааг 2018 оноос жил бүр авч байна. Энэхүү судалгааны дундаж үзүүлэлт нь жил бүр жигд өсөлттэй байгаа нь оюутанд үйлчлэх зөвлөн туслах үйл ажиллагаа сайжирч байгааг илтгэж байна. Судалгаанд тус хөтөлбөрөөр суралцдаг 127 оюутан хамрагджээ.
- Оюутны үйлчилгээний нэг хэсэг бол Номын сангийн үйлчилгээ байдаг. ХААИС-ийн номын сангийн ажилтнуудыг оюутнууд 3 үзүүлэлт (үйлчилгээний чанар, харилцааны соёл-ёс зүй, зөвлөн туслах үйлчилгээ)-ээр дүгнэхэд дунджаар 5 онооноос 3,78 үнэлгээг оюутнууд өгсөн байна.

- Оюутны эрүүл мэнд, ёс зүйг дээшлүүлэх зорилготой лекц, сургалтыг жилд 1-2 удаа тогтмол зохион байгуулдаг. ХААИС-ийн оюутнуудад зориулсан ёс зүй, төлөвшилтэй холбоотой 4 бүлэг ажлыг тогтмол зохион байгуулдаг. Үүнд: Оюутны сурч боловсрох үйл ажиллагааг дэмжих, Оюутны чөлөөт цагийг зөв өнгөрүүлэхэд чиглэсэн урлаг соёлын үйл ажиллагаа, Оюутныг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд татан оролцуулах, Оюутны ёс зүй төлөвшлийг дээшлүүлэх. Тайлант хугацаанд дээрх чиглэлээр 13 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.
- “Оюутны хөгжил хөтөлбөр”-ийн боловсруулалт сайн.
- Оюутныг судалгаа шинжилгээний ажилд татан оруулцах, ёс зүй төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа хангалттай сайн.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны дүнд үндэслэн дараагийн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөгөө гаргадаг циклийг бүрдүүлэн ажилласнаас сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтүүд тогтмол өсөлттэй байна.
- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн оюутнууд “онолын хичээл, танхимын хичээлээ хээрийн дадлагаар баталгаажуулдаг. Хээрийн дадлага нь хагас цэрэгжилтийн зохион байгуулалтаар явдаг бөгөөд багш нар дадлагын орой бүр өдрийн ажлын боловсруулалтыг шалгаж баг болгонд зөвлөгөө өгдөг” гэж ярилцлагын үеэр дурдсан нь оюутныг амжилттай суралцахад багш бүр сэтгэл зүрхнээсээ ажиллаж, хичээлийн уялдаа холбоог сайтар хангаж байгаа илтгэж байна.

### **Шинжээчийн үнэлгээ:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Зөвлөн туслах үйлчилгээнд өгөх суралцагчдын сэтгэл ханамж сайжирсан байна. Гэхдээ хүртээмжийн хувьд нөхцөл байдал тодорхой биш, зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, арга зүйч зэргийн тоо нь нийт оюутанд харьцуулахад хэр хүртээмжтэй болон сард болон жилд дунджаар суралцагчдын хэдэн хувьд зөвлөгөө өгдөг зэрэг үзүүлэлтээр үйлчилгээний чанарыг дүгнэх

#### **Зөвлөмж:**

- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш нарт өгсөн суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаанаас харахад үйлчилгээний чанар сайжирч байгаа хэдий ч 20-30% нь сэтгэл ханамжгүй тул сайжруулах арга хэмжээгээ тасралтгүй үргэлжлүүлэх
- Сэтгэл ханамжийн судалгаанаас гадна суралцагчдад шаардлагатай болон тулгамдаж буй асуудлыг шийдэхэд орхигдож буй үйлчилгээний талаар санал хүсэлт авах, үйлчилгээндээ тогтмол шинэчлэлт, сайжруулалт хийж байх

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн хэмжээнд “Ланд лимит” клуб, “Ланд менежер клуб”, “Бэлчээр судлаач клуб”, Open data MULS” клубүүд тогтмол үйл ажиллагаатай ажилладаг.
- ХААИС-ийн Оюутны холбооноос 2016 онд Цэвэр сургууль-бидний орчин” сургуулийн ширээ сандлын цэвэрлэгээ, 2017 онд Сэлбэ голын хөвөөнд мод тарих сайн дурын ажил, 2017-2019 онд “Дусал цус-нэг амь” өдөрлөгүүдийг тус тус зохион байгуулсан байна.

- Урлаг, спорт, мэргэжлийн уралдаан тэмцээнүүдэд идэвхтэй оролцдог. 5 жилийн хугацаанд давхардсан тоогоор 121 оюутан уралдаан тэмцээнд оролцсон байна.
- Улсын болон сургуулийн тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлтөд хамрагдсан оюутны тоо жил бүр өсөлттэй байна.
- ХААИС-ийн “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг 2009 онд байгуулсан. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Job Fair” өдөрлөгийг зохион байгуулсан.
- 2020 оноос ХААИС-ийн Агроэкологийн сургуулиас “Цалинтай оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 90 оюутныг ногоо хураах цалинтай ажилд хамруулсан.

#### **Шинжээчийн үнэлгээ:**

БҮРЭН ХАНГАСАН

#### **Анхаарах асуудал:**

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Job Fair” өдөрлөгийг тогтмол зохион байгуулж, төгсөгчдийг ажлын байранд зуучлах, оюутныг хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн сайжруулах
- Оюутныг сайн дурын ажилд татан оролцуулах ажил идэвхитэй ч түүнийг үнэлэх үнэлгээний системийг бүрдүүлж, баримтжуулалт, батламж өгдөг байх

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

- ХААИС-ийн оюутнуудын шилжилт хөдөлгөөнийг “ХААИС”-ийн бакалаврын сургалтын журам”-ын 5-д заасны дагуу зохицуулдаг.
- Өөрийн үнэлгээний тайлант хугацаанд (сүүлийн 5 жил) шилжин явсан 58 оюутан байна. Үүнээс ХААИС-ийн бусад хөтөлбөрт шилжин суралцсан 16, бусад их дээд сургуульд шилжсэн 42 байна.
- Дээрх хугацаанд шилжин ирсэн 66 оюутан байна. Үүнээс ХААИС-ийн бусад хөтөлбөрөөс шилжин суралцсан 37, дотоодын бусад их дээд сургуулиас 38 оюутан, гадаадын их дээд сургуулиас 3 оюутан шилжин ирсэн байна.
- Шилжин ирсэн оюутны тоо шилжин явсан оюутны тооноос илүү байгаа ч сургуулиас чөлөөлөгдсөн оюутны тоо тайлант хугацаанд 227 байна.
- Жилийн чөлөө авсан, төгсөөгүй оюутнуудыг эргэн суралцуулах зорилгоор 2020 онд Inbound маркетинг арга хэмжээг зохион байгуулж, 29 оюутан эргэн суралцан төгссөн бол одоо 24 оюутан тус хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцаж байна.

#### **Шинжээчийн үнэлгээ:**

БҮРЭН ХАНГАСАН.

#### **Анхаарах асуудал:**

- Шилжилт хөдөлгөөний тоон үзүүлэлтээс сургуулиас чөлөөлөгдсөн оюутны тоо элсэлтийн тоотой харьцуулахад 46.6 хувьтай тэнцэж байгаа нь хэт өндөр үзүүлэлт бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тал дүгнэлт хийн, хөтөлбөрийн нэр хүндийг өсгөх, хөтөлбөрт элсэгчдийг зөв сонгон шалгаруулах, суралцах үйл явцыг дэмжих ажлыг системтэй сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

### **Зөвлөмж:**

- Жилийн чөлөө авсан, төгсөөгүй оюутнуудыг эргэн суралцуулах зорилгоор зохион байгуулсан Inbound маркетинг арга хэмжээг бусад их дээд сургуулиудад хэрэгжүүлж буй туршлагаудтай харьцуулалт хийж, туршлага судлах
- Сургуулиас чөлөөлөгдсөн оюутны тоо элсэлтийн тоотой харьцуулахад өндөр байна. Энэ асуудлыг шийдэхэд шалтгааныг тодруулах үүднээс судалгаа авч, үүнд үндэслэн арга хэмжээ төлөвлөх

### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### **Баримт нотолгоо:**

- ХААИС-ийн оюутны төгсөлтийн баримт бичгийг БСШУ-ны сайдын 2012 оны “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу ХААИС-ийн Захирлын тушаалаар төгссөн мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг, диплом, энгэрийн тэмдэг олгодог.
- Газар зохион байгуулалт хөтөлбөр нь MNS 5323-6:2004 стандартын дагуу дээд боловсрол олгодог.
- “ХААИС-ийн оюутан бүр төгсөлтийн ажил бичиж хамгаална” гэж ХААИС судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд зааж өгсөн бөгөөд Газар зохион байгуулалт хөтөлбөрийн төгсөгчид бүгд төгсөлтийн ажил бичиж хамгаалдаг.
- Төгсөгчдийн дүнгийн нэгдсэн хүснэгт, диплом болон хавсралтын хуулбар, дүнгийн дэвтэр, тойрох хуудас ХААИС-ийн архивд хадгалагддаг.

#### **Шинжээчийн үнэлгээ:**

##### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөлтийн ажлыг 4 жил онц сурсан оюутнаас шилж сонгож төгсөлтийн ажил бичүүлж төгсгөх боломжтой бөгөөд бусад дундаж сурлагатай оюутнуудыг улсын шалгалт авч төгсгөхөөр хөтөлбөрт тусгах саналтай байна. Харин бүх оюутнуудыг төгсөлтийн ажил бичүүлэх тохиромжгүй байна. Амжилттай сайн сурсан оюутан, дундаж сурсан оюутнуудын ялгаа алга болж байна.

#### **Зөвлөмж:**

- Суралцагч оюутны төгсөлтийн үйл ажиллагааны өмнө явагдах дүн тулгалтын ажлыг автоматжуулах, боловсронгуй болгох
- Төгсөлтийн баримт бичигт оюутны ур чадварын чадамжийг тодорхойлсон хавсралтыг олгох

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Баримт нотолгоо:**



- ХААИС-ийн захирлын 2017 оны 4-р сарын 20-ны 60 тоот тушаалаар “ХААИС-д профессор багш ажиллуулах журам”-ын дагуу багшийг сонгон шалгаруулж ажилд авдаг.
- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн хүний нөөцийн бодлого тогтвортой, тайлант хугацаанд тогтмол 24 багштай байсан бөгөөд 2 багш өндөр насны тэтгэвэрт гарч, 3 багш чөлөө авснаас өөр өөрчлөлтгүй.
- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн багш нарын хүйсийн харьцаа тэнцвэртэй (эмэгтэй 58%, эрэгтэй 42%), докторын зэрэгтэй багш 42%, эрдмийн зэрэг цолтой багш 42% байна. Багш нарын ажилласан жил 8-22 жил байна.
- Нэг багшид ногдох оюутны тоо 2015-2016 онд 1:21 байсан бол 2019-2020 онд 1:11 болсон нь оюутны тооны бууралттай холбоотой ч тус хөтөлбөрөөр суралцагчдад багш нэг бүр хүрч ажиллах бүрэн боломжтой байна.
- Багшийн албан тушаалыг 5 шатлал буюу профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн 5 зэрэглэлтэй бөгөөд зэрэглэл тус бүрд тавигдах шаардлагыг ажлын байрны тодорхойлолтод ерөнхий болон тусгай шаардлагаар тусгаж өгдөг.
- ХААИС-ийн багш нарын сургалтын ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг тооцох журмын дагуу багшийн ажлын үр дүнг үнэлдэг. Багшийн ажлыг сургалт (А цаг), эрдэм шинжилгээ (Б цаг), мэргэжлийн үйлчилгээ (Б цаг)-нд зарцуулах 48 цагийг 1 багц цагт тооцно. Багшийн жилд гүйцэтгэх ажлын цагийн норм албан тушаалын зэрэглэлээс хамаарч А цаг 14-18, Б цаг 7-11 байна. Мөн хөтөлбөрийн удирдах албан тушаалтанд Б цагийн норм тогтоож өгдөг.
- ХААИС нь багшийн ажлыг үнэлж, урамшуулах 8 журмыг мөрдөн ажилладаг. Үүнд:
  - ХААИС-ийн профессор багш ажиллуулах журмын дагуу илүү цаг урамшуулал олгох журам
  - Оны шилдэг бүтээл, технологиор урамшуулал авах журам
  - Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацын тэтгэлэг олгох журам /БСШУ-ны Сайдын 2011 оны 222 тоот тушаал/
  - Магистрант, докторантын шилдэг бүтээлд тэтгэлэг олгох журам
  - ХААИС-ийн судалгааны төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журам
  - Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журам /БСШУ-ны Сайдын 2010 оны 479 тоот тушаал/
  - ХААИС-ийн Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулдаг хамтын гэрээ болон бусад урамшууллын системээр оны шилдэг бүтээлийг шалгаруулах, эрдэм шинжилгээ, инновацыг дэмжих, судалгааны төслийн грант олгох, профессорын багийн гишүүдэд кредитийн хөнгөлөлт үзүүлэх, жилд 1 удаа үйлдвэрчний эвлэлийн гишүүний урамшуулал олгох, докторын дараах сургалтад хамрагдсан багш нарт хөнгөлөлт урамшуулал олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг.
- Дээрх журмуудын хүрээнд Газар зохион байгуулалт хөтөлбөрийн 1 багш докторын дараах судалгааны грант, 2 багш докторын сургалтын төлбөрийн 40 хувийн хөнгөлөлт, 2 багш 3 сарын цалинтай чөлөөгөөр гадаадад мэргэжил дээшлүүлж, 1 багшийн бүтээлийг Амазон цахим худалдаанд байршуулах зардал зэрэг нийт 58 багш тайлант хугацаанд ямар нэгэн урамшуулал, тэтгэлэг, төлбөрийн хөнгөлөлт, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангагджээ.
- ХААИС нь багш ажилчдын нийгмийн асуудалд ихээхэн анхаардаг бөгөөд тус хөтөлбөрийн 5 багш хөнгөлөлттэй үнээр орон сууцанд орсон байна.



### **Шинжээчийн үнэлгээ:**

БҮРЭН ХАНГАСАН

#### **Анхаарах асуудал:**

- Багш нараас сүүлийн 5 жилд докторын зэрэг хамгаалаагүй.
- Багш нарын гадаад хэлний мэдлэг сул тул олон улсын өндөр зэрэглэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлж буй байдал цөөн.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилт бага.
- Багшийн залгамж халааг бэлдэх тогтолцоо дутмаг.

#### **Зөвлөмж:**

- Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь 41.6 хувь байна. Тайлант хугацаанд доктор хамгаалсан багш байхгүй. Цаашид магистрын зэрэгтэй 14 багшийг үе шаттайгаар докторын зэрэг хамгаалуулах ажлыг хөдөлмөрийн гэрээнд тусган хамгаалуулахад анхаарах
- Багш нарын хэлний болон мэргэжлийн чадавхийг сайжруулахын тулд урт, богино хугацааны чанартай сургалтанд хамруулах арга хэмжээ авах
- Сургалт-Судалгаа-Эрдэм шинжилгээний ажлын уялдаа холбоог сайжруулах, бэхжүүлэх

#### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Баримт нотолгоо:**

- ХААИС-аас “Багшийн хөгжил” хөтөлбөрийг 2018 онд шинэчлэн боловсруулж, Тус хөтөлбөрт их сургуулийн хөгжлийн стратеги зорилго, зорилттой уялдуулан профессор багш нарыг үе шаттайгаар хөгжих таатай нөхцөл бүрдүүлж, багшийн чадамжийг тодорхойлж, тасралтгүй хөгжих үйл явцыг тусгасан.
- “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд ХААИС-ийн багшийн чадамжийн хүрээг тодорхойлсон Үүнд: Мэдлэг оюуны чадамж, Менежментийн үр ашгийн чадамж, Судалгааны чадамж, Сурахуйн чадамжууд байна. Тайлант хугацаанд тус хөтөлбөрийн багш нар 9 төрлийн чадамжийн сургалтад хамрагдаж, давхардсан тоогоор 127 багш оролцжээ. “ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам”-ын 2019 онд баталж, багш нарын чадамжийг дадлагажигч багш 2 жил тутам, ахлах багш 3 жил тутам, дэд профессор 4 жил тутам, профессор 5 жил тутам заавал үнэлүүлдэг.

### **Шинжээчийн үнэлгээ:**

БҮРЭН ХАНГАСАН

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн чадамжийн хүрээг тогтмол тодорхойлдог ч тус хөтөлбөрийн багш нарын хүрээний зураглал, түүний үр дүнд багшийн хөгжлийн ойрын болон урт хугацааны төлөвлөлтийг гаргахад анхаарах

#### **Зөвлөмж:**

- Багш нарын хэрэгжүүлж буй төсөл, гэрээт ажлаар дамжуулан хэлний чадварыг нэмэгдүүлэх, судалгааны ажлын түвшин ахиулах

#### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

### **Баримт нотолгоо:**

- ХААИС нь судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд профессор багш бүр мэдлэгийн менежер байж, өөрийнхөө судалгаанд суурилсан гарааны компаниудыг байгуулах гэсэн зорилтыг тавьсан.
- Тайлант хугацаанд Газар зохион байгуулалт хөтөлбөрийн багш нар 11 сурах бичиг, 11 нэгэн сэдэвт бүтээл, 12 гарын авлагыг хэвлүүлсэн. 21 зохиогчийн эрхийн гэрчилгээг авчээ.
- Профессор багш нар оюутнуудыг судалгааны ажилд идэвхтэй оролцуулж, сүүлийн 5 жилийн хугацаанд гадаадын төсөлд 13 оюутан, дотоодын төсөлд бакалаврын түвшний 3, магистрын түвшний 3 оюутныг тус тус хамруулсан.
- 2016-2020 онд тус хөтөлбөрийн багш нар ШУТ, инновацын 6 төсөл, гадаадын 27 төсөл, 96 гэрээт ажлуудыг хэрэгжүүлж, оролцжээ.
- Олон улсын IF болон Web of Science-д бүртгэлтэй сэтгүүлд 1, Scopus, H index бүхий сэтгүүлд 4, гадаадын сэтгүүлд гадаад хэлээр 55, улсын хэмжээнд 182, сургуулийн хэмжээнд 7 өгүүлэл хэвлүүлсэн. Олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй индекслэгдсэн сэтгүүлд 19 удаа ишлэгдсэн байна.
- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн багш нар 2016-2020 онд нийт 149 удаа эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлснээс олон улсын хэмжээнд 25, улсын хэмжээнд 87, сургуулийн хэмжээнд 37 илтгэл тус тус хэлэлцүүлжээ.
- ХААИС-ийн Агроэкологийн сургуулиас ISSN дугаар бүхий “Агроэкологи” сэтгүүлийг эрхлэн хэвлүүлдэг.
- Тус хөтөлбөрийн бакалаврын оюутнууд 100 хувь судалгааны ажил бичиж төгсөлтийн ажлаа хамгаалдаг бөгөөд 2016-2020 онд нийт 447 оюутны төгсөлтийн судалгааны ажлыг тус тэнхимийн багш нар удирдан хамгаалуулсан.

### **Шинжээчийн үнэлгээ:**

БҮРЭН ХАНГАСАН

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн нийт 24 багшийн 18 багш нь судалгааны чиглэлээ тодорхойлсон. 6 багшийн судалгааны чиглэлийг тодорхойлж, эрдэм шинжилгээний ажилд татан оролцуулах, цаашид эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд дэмжлэг үзүүлэхэд анхаарах

### **Зөвлөмж:**

- Багшид чиглэсэн эрдэм шинжилгээний зардлыг холбогдох журамд заасны дагуу сургуулийн санхүүгийн чадамжид суурилан тодорхой хувиар нэмэгдүүлэхэд анхаарах
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжин санхүүжилтийг төлөвлөгөөтэй, ил тод, шударга зарчмаар явуулах журам боловсруулах
- Сургалт, судалгааны ажилд тодорхой хөрөнгө төсөвлөж, багш, судлаач оюутныг төсөл, хөтөлбөрт хамруулснаар судалгааны их сургууль болох зорилтыг хэрэгжүүлэх

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

### **Баримт нотолгоо:**

- Багшийн чадамжийн үнэлгээг албан тушаалын зэрэглэлээс хамааран тогтмол хугацаанд үнэлдэг. Багшийн ажлын үнэлгээг “Багшийн хөгжил” хөтөлбөр,

“ХААИС-ийн профессор багшийн ажиллах журам” зэрэг эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд үнэлдэг.

- Багшийг үнэлэх оюутны сэтгэл ханамжийн үнэлгээгээр дундаж үнэлгээ 3.9-4.4 буюу сайн гэсэн үзүүлэлттэй байна.
- Тайлант хугацаанд 2 багш дэд профессорын зэрэглэлд, 1 багш ахлах багшийн зэрэглэлд, 3 багш багшийн зэрэглэлд дэвшин ажилласан. Тайлант хугацаанд доктор хамгаалсан багш байхгүй.

#### **Шинжээчийн үнэлгээ:**

##### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 5 жилд 3 багш дэд профессор зэрэг ахиснаас өөр ахиц байхгүй тул багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг идэвхжүүлэх асуудалд анхаарвал зохино.
- ХААИС болон мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хослуулах боломжоор сургуулийн зүгээс хангах нь хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх хүчин зүйл болно.

#### **Зөвлөмж:**

- Багшийн сурган заах арга, хэлний мэдлэгт онцгой анхаарч бүх талаар хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөтэй системтэй авч явуулах
- Багш нарын хувьд орчин үеийн техник технологийн дэвшлээс хоцрохгүй байнга өсч хөгжихөд нь дэмжлэг үзүүлдэг байх

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Баримт нотолгоо:**

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт нь оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусгасан эрхэм зорилго, зорилтыг хангах, чанар, үр дүнг эрхэмлэсэн хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах зорилготой дотоод соёлыг хөгжүүлэн ажиллаж байна.
- Тус хөтөлбөрийн хэтийн болон дунд хугацааны үйл ажиллагааг төлөвлөсөн “ГЗБ хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө 2017-2024”-г боловсруулж МХХ-ы 2018 оны 05 сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцэн батлаж, мөрдлөг болгон ажиллаж байна.
- Чанарын удирдлага, зохицуулалтын алба ХААИС-ийн Захирлын 2018 оны Б/283 дугаар тушаалаар үүсгэн байгуулагдан, хүний нөөц, хяналт, шалгалт, үнэлгээ болон чанарын баталгаажуулалт гэсэн 3 үндсэн үйл ажиллагааг удирдан ажилладаг байна.
- ХААИС нь хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангах удирдлага зохион байгуулалтын 3 түвшнээс бүрдсэн хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хөтөлбөрийн хороо, мэргэжлийн хөтөлбөрийн хороо гэсэн 3 бүтэцтэй байна. Ерөнхий хороо ерөнхий удирдлагаар хангана, хөтөлбөрийн дэд хороо ерөнхий хорооноос өгсөн чиг үүргийн дагуу хэрэгжилтийн хангана.

- Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талууд хөтөлбөр хэрэгжилтийн бүх үйл ажиллагаанд тодорхой үүрэгтэй ажилладаг.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем.
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

### **Шалгуурыг хангасан байдал:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөрийг тодорхой болгох анхаарах
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын нэгдсэн тогтолцооны уялдаа сул байгаагаас хөтөлбөрийн стратеги, төлөвлөлтөд заагдсан зорилтууд тэнхим, нэгждээ хэрэгжүүлэх боломж, хэрэгжилт муу үр дүнтэй байна.

#### **Зөвлөмж:**

- ХААИС-ийн Чанарын удирдлага, зохицуулалтын алба нь чиг үүргийн дагуу хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо, бодлогыг ХААИС-ийн сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журамд оруулж батлуулан мөрдөх
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалттай холбоотой заалтуудыг ХААИС-ийн дүрэм, журамд оруулан батлуулж мөрдөх. Дүрэм журмын дагуу СБЗА, тэнхим, хөтөлбөрийн хороо, багш нар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж, тайландаа жил бүр оруулдаг байх

### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Баримт нотолгоо:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

### **Шалгуурыг хангасан байдал:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- 2021 оны үр дүнгээс судлахад ГЗБ хөтөлбөр төгссөн төгсөгчдийн 69% нь жилийн дотор ажлын байраар хангагдсан байна. Төгсөгчдийн ажлын байрны нийцэл, карьер өсөлт, ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацааны судалгааг тогтмолжуулах шаардлагатай.

- Ажил олгогч мэргэжлийн холбоодоос авсан судалгаагаар тус хөтөлбөрийн төгсөгчийг ажилуулж байгаа судалгаанд оролцогч нарын 89% нь сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн бол 11% нь дунд гэсэн үнэлгээг өгсөн байна.
- ХААИС, АЭС-ийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн бүтээл нь АЭС-ийн хөтөлбөрүүдээр ангилж салгаагүй тул ашиглахад хүндрэлтэй, үр дүн муутай байна.

#### **Зөвлөмж:**

- Сэтгэл ханамжийн судалгаануудыг оролцогч талуудаас цахимаар авах, загваруудыг эцэслэн батлах, судалгааны үр дүнг хөтөлбөр бүрээр салгаж тайлагнах

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь
- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2015 оны 05 сарын 06-ны өдрийн тогтоолоор батлагдсан гэрчилгээг авсан бөгөөд БМИҮЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу хөтөлбөрийн үйл ажиллагаанд дараах сайжруулалтыг хийсэн байна. Үүнд: ОХУ-ын Москва хотын ГЗБ-ын их сургуультай хамтран ажиллаж туршлага солилцсон байна, урт хугацааны хөтөлбөрт өөрчлөлт оруулан сургалтын богино улирлын системд шилжсэн, хичээлүүдийн уялдаа холбоог сайжруулсан, багш нарын олон улсын зэрэглэл өндөртэй сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлэх тоо ихэссэн, суралцагсад үнэлгээний нээлттэй ил тод байдлыг нэвтрүүлэх тал дээр анхаарсан байна.
- 2020 оны байдлаар нийт 48 төгсөгч гадаадын их дээд сургуульд элсэн суралцаж түүнээс докторын түвшинд 5 төгсөгч суралцаж байна.
- МГЗБХ, Монголын геомэдээллийн холбоодтой эрдэм шинжилгээний хурал, мэргэшсэн болон зөвлөх инженерүүд бэлтгэх сургалтад хамтран ажилласан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал:**

##### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Анхаарах асуудал:**

- ХААИС нь хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хангах нэгж, алба байгаа хэдий ч тэдгээрийн явуулж байгаа үйл ажиллагаа, бодлогууд нь хоорондоо уялдаа муу.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн зөвшөөрөгдсөн байдлыг улам сайжруулан сургалтын чанарыг дээшлүүлэх, хөтөлбөрөөр төгсөгчид болон ажил олгогч нарын саналыг хөтөлбөрт тусган оруулж, сайжруулалтыг тогтмол хийх

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

**ДҮГНЭЛТ**

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	1.1 1.2 1.3	0	0	
2	Сургалтын үйл ажиллагаа	2.1 2.2 2.3	0	0	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	3.3	3.1, 3.2	0	- Нэг оюутанд ногдох анги танхимын талбайн хэмжээ, нэг оюутанд ногдох мэргэжлийн ном, сурах бичгийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай. - Албан ёсны лицензийн эрхтэй мэргэжлийн програмуудыг ашиглах шаардлагатай. - Зарим шаардлага хангахгүй, хүчин чадал хүрэлцэхгүй, мэргэжлийн програм дээр ажиллахад хүндрэлтэй компьютерүүд болон эд ангийг сольж шинэчлэх шаардлагатай.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.1 4.2 4.3 4.4	0	0	
5	Суралцагчид чиглэсэн үйлчилгээ	5.1 5.2 5.3	0	0	
6	Багшлах бүрэлдэхүүн	6.1 6.2	0	0	

7	Чанарын үнэлгээ, баталгаажуула	7.1 7.2 7.3	0	0	
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан-24, Хэсэгчлэн хангасан-2, Хангаагүй-0</b> <b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийн “Газар зохион байгуулалт (D053211)” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг “Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик” чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

### ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	Хөдөө аж ахуйн их сургууль
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Газар зохион байгуулалт
<b>Хөтөлбөрийн индекс</b>	D053211
<b>Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт</b>	<ul style="list-style-type: none"> <li>➢ Гадаад орны ижил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулахад газарзүйн мэдээллийн систем, тандан судлалын хичээлээр бусад сургуулиудаас бага кредиттэй байгаа бөгөөд хөрс судлал, ургамал судлал, бэлчээр судлал, усан хангамж гэх мэт хичээлийн багц цагийг багасгах тал дээр цаашид анхаарах</li> <li>➢ Төгсөгчдөд шинээр орох ажлын байрны тооцоо судалгаанд үндэслэж элсэгч, төгсөгч нарын хүрэлцээ, хангамжийн асуудалд анхаарах</li> <li>➢ Хөтөлбөрийн зорилго, өөрчлөлтийн талаар нийтэд нээлттэй мэдээллэх, мэргэжил сурталчлах, ажил олгогчдыг татан оролцуулах</li> <li>➢ Төгсөгчид нь мэргэжлийн програм болон газрын хууль эрхзүйн талаарх ойлголт ур чадварыг бүрэн эзэмшиж ажлын байранд ашиглах мэдлэгийн тал дээр анхаарах</li> <li>➢ Газрын менежментийн ур чадварын талаар хөтөлбөрт нэлээд дэлгэрэнгүй оруулж өгөх. Газар зохион байгуулалтын мэргэжлийн бүрэлдэхүүн хэсэгт менежментийн асуудлын талаар уг хөтөлбөрт, хүрэх үр дүнд тодорхой тусгах.</li> </ul>
<b>Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>➢ Шинээр бэлтгэгдэж буй ажилтнуудад багаар ажиллах чадвар, санаачлагатай, бүтээлч, бие даах чадвартай байх тухай ойлголтыг олгох, цаашид мэргэжлээрээ өсөн бойжиход зайлшгүй анхаарах. Хичээлийн явц сэдэв болгонтой холбогдуулж уг чадварыг оюутанд эзэмшүүлэх</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хичээл нэг бүрийн үнэлгээ болон шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд шинжилгээ хийж үр дүнд үндэслэн тогтмол шинэчлэлт сайжруулалт хийж байх</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	<ul style="list-style-type: none"> <li>➤ Газар зохион байгуулалтын мэргэжлийн олдоц бага, ховор сургалтын сурах бичиг, номуудыг нэмэгдүүлж хүртээмжид анхаарах</li> <li>➤ Сургалтын орчныг сайжруулах, хэрэглэгдэхүүний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, хичээллэх боломж нөхцлөөр бүрэн дүүрэн хангахад анхаарах</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Сургалтад хийгдэж байгаа дүн шинжилгээ, хурлаар хэлэлцэж буй тайлан, төлөвлөгөө зэргийг үндэслэн олсон ололт алдаа дутагдлаа тооцон гаргаж сургалтын хөтөлбөртөө холбогдсон асуудлыг сайжруулахад ажлын хэсэг гарган ажиллаж байх</li> <li>➤ Хичээлийн бус цагаар багш нараас гадна төрийн, хувийн, эрдэм шинжилгээний байгууллагуудын мэргэжилтэн, инженер, судлаач нараар хичээл заалгах, мэдлэг мэдээлэл танилцуулах, үйл ажиллагааг зохион байгуулдаг болох</li> <li>➤ Судалгааны байгууллагуудад судлаач оюутнуудыг дадлагажуулах боломж нээж өгөх</li> <li>➤ Дадлага, ном бүтээл гаргах редакцийн зөвлөл, практик дадлагын ажлын зардалд санхүүжилтийг судалгааны тооцооны үндсэн дээр нэмэгдүүлэх</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>➤ Цаашид элсэгчдийн хүсэл сонирхол, ойлголтыг сайжруулахын тулд дунд сургуулийн сурагчдад мэргэжлийн онцлог давуу талыг харуулсан төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлж байх</li> <li>➤ Онол арга зүйн чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд мэргэжлийн чиглэлийг хөгжүүлэх, орчин үед тавигдаж байгаа ажил мэргэжлийн онолын суурь мэдлэгийг эзэмшүүлэх</li> <li>➤ Оюутнуудын идэвх санаалчилгыг ном унших, хийж бүтээх хандлагад чиглүүлэх, дотоод, гадаадын ижил төстэй сургуультай хамтран ажиллах, онц сурдаг, идэвх зүтгэлтэй оюутнуудыг гадаадад суралцуулах, багш бусад хүмүүстэй холбоо тогтоох, оюутныг эрдэм шинжилгээний ажилд хамруулах, тэдгээрийг урамшуулах</li> </ul>
Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> <li>➤ Олон улсын болон эрдэм шинжилгээ инновацийн бүтээгдэхүүн гаргахад санхүү дэмжлэг нэмэгдүүлэх.</li> <li>➤ Сургууль дээр хэрэгжүүлдэг багш оюутны хамтарсан дотоод, гадаадын төсөл хөтөлбөрт оюутнуудыг хамруулах, хамтарсан судалгаа хийх, өгүүлэл бичих</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> <li>➤ ХААИС-ийн Чанарын удирдлага, зохицуулалтын алба нь чиг үүргийн дагуу хөтөлбөрийн чанарын</li> </ul>



	<p>баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо, бодлогыг ХААИС-ийн сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журамд оруулж батлуулан мөрдөх</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалттай холбоотой заалтуудыг ХААИС-ийн дүрэм, журамд оруулан батлуулж мөрдөх. Дүрэм журмын дагуу СБЗА, тэнхим, хөтөлбөрийн хороо, багш нар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж, тайландаа жил бүр оруулдаг байх</li> <li>➤ Сэтгэл ханамжийн судалгаануудыг оролцогч талуудаас цахимаар авах, загваруудыг эцэслэн батлах, судалгааны үр дүнг хөтөлбөр бүрээр салгаж тайлагнах</li> <li>➤ Хөтөлбөрийн зөвшөөрөгдсөн байдлыг улам сайжруулан сургалтын чанарыг дээшлүүлэх, хөтөлбөрөөр төгсөгчид болон ажил олгогч нарын саналыг хөтөлбөрт тусган оруулж, сайжруулалтыг тогтмол хийх</li> </ul>
<p><b>ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/</b></p>	
	<ul style="list-style-type: none"> <li>➤ Нэг оюутанд ногдох анги танхимын талбайн хэмжээ, нэг оюутанд ногдох мэргэжлийн ном, сурах бичгийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.</li> <li>➤ Албан ёсны лицензийн эрхтэй мэргэжлийн програмуудыг ашиглах шаардлагатай.</li> <li>➤ Зарим шаардлага хангахгүй, хүчин чадал хүрэлцэхгүй, мэргэжлийн програм дээр ажиллахад хүндрэлтэй компьютерүүд болон эд ангийг сольж шинэчлэх шаардлагатай.</li> </ul>

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг .....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Нэр	Эрдмийн зэрэг, цол	Албан тушаалын зэрэг	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Т.Балжинням	Доктор, дэд проф	Зөвлөх профессор	21-ээс дээш	Геодези
2	Д.Түвшинбаяр	Доктор, дэд проф	профессор	16-20 жил	Зураг зүй
3	С.Сайнбаяр	Доктор	Зөвлөх профессор	16-20 жил	ГЗБ эдийн засаг
4	Ш.Гэрлээ	Доктор	Дэд профессор	16-20 жил	Газрын мониторинг, Зам шугам сүлжээний төлөвлөлт
5	Л.Уранбилэг	Доктор	Дэд профессор	16-20 жил	Газар зохион байгуулалтын төлөвлөлт Хот төлөвлөлт
6	И.Мягмаржав	Доктор	Дэд профессор	16-20 жил	Газрын эрх зүйн зохицуулалт, Газрын мониторинг
7	Ч.Баасанжаргал	Доктор	Ахлах багш	16-20 жил	Газрын эрх зүй, Газрын эрх зүйн зохицуулалт
8	Ц.Энхзаяа	Доктор	Ахлах багш	16-20 жил	Зайнаас тандсан судлал
9	Б.Батбилэг	Доктор	Ахлах багш	16-20 жил	ГМС, Зайнаас тандан судал
10	Р.Нямсүрэн	Магистр	Ахлах багш	21-ээс дээш	Геодези Байр зүй
11	Э.Эрхэмбаяр	Магистр	багш	11-15 жил	ГЗБ төсөлжүүлэлт ГЗБ онолын үндэс
12	Т.Шинэбаяр	Магистр	Ахлах багш	11-15 жил	Газрын кадастр, Кадастрын зураглал
13	Д.Мөнхцэцэг	Магистр	Дагалдах багш	6-10 жил	ГМС, Газрын мэдээлийн сан
14	Б.Сэр-Од	Магистр	багш	11-15 жил	ГМС, Газрын мэдээлийн сан
15	Ж.Сарангэрэл	Магистр	Дагалдах багш	6-10 жил	Газрын үнэлгээ 1,2 ҮХХ үнэлгээ
16	Л.Базарзагд	Магистр	Дагалдах багш	6-10 жил	
17	Б.Эрдэнэтуяа	Магистр	багш	11-15 жил	ГМС, Зайнаас тандан судлал
18	Д.Бямбасүрэн	Магистр	багш	11-15 жил	ХАА-н газрын чанарын үнэлгээ Хот суурин газрын үнэлгээ
19	Ж.Эрдэнэчандмань	Магистр	Ахлах багш	11-15 жил	Нөөцийн кадастр Газрын кадастр
20	Б.Хулан	Магистр	Дагалдах багш	6-10 жил	Хотын кадастр, Харилцаа инноваци
21	Х.Мөнх-Ирээдүй	Магистр	Дагалдах багш	6-10 жил	Газрын үнэлгээ

## II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Анги	Утас	Цахим хаяг
1	Энхзул	ГЗБ-1	80384830 89660112 91224830	<a href="mailto:4120020@mul.s.edu.mn">4120020@mul.s.edu.mn</a>
2	Үүрцайх	ГК-1	86862890	<a href="mailto:4820005@mul.s.edu.mn">4820005@mul.s.edu.mn</a>
3	Ганцэцэг	ГК-2	90502052	<a href="mailto:4419001@mul.s.edu.mn">4419001@mul.s.edu.mn</a>
4	Эрдэнэбулган	ГК-2	95912494	<a href="mailto:4118054@mul.s.edu.mn">4118054@mul.s.edu.mn</a>
5	Баатарзориг	ГК-2	88587462	<a href="mailto:4118081@mul.s.edu.mn">4118081@mul.s.edu.mn</a>
6	Нүрзэдмаа	ГЗБ-2	86611698	<a href="mailto:4119034@mul.s.edu.mn">4119034@mul.s.edu.mn</a>
7	Мөнхжаргал	ГЗБ-2	80182392	<a href="mailto:4119015@mul.s.edu.mn">4119015@mul.s.edu.mn</a>
8	Номин	ГҮ-3	89868055	<a href="mailto:4118042@mul.s.edu.mn">4118042@mul.s.edu.mn</a>
9	Бүрэнбаяр	ГҮ-3	89772294	<a href="mailto:4118109@mul.s.edu.mn">4118109@mul.s.edu.mn</a>
10	Ням	ГЗБ-3	80601522	<a href="mailto:4118099@mul.s.edu.mn">4118099@mul.s.edu.mn</a>
11	Цэндсүрэн	ГЗБ-3	85850367	<a href="mailto:4118022@mul.s.edu.mn">4118022@mul.s.edu.mn</a>
12	Өгөөдэй	ГЗБ-3	89092726	<a href="mailto:4118045@mul.s.edu.mn">4118045@mul.s.edu.mn</a>
13	Мөнхцолмон	ГЗБ-3		<a href="mailto:4118030@mul.s.edu.mn">4118030@mul.s.edu.mn</a>
14	Батзориг	ГЗБ-3	88630770	<a href="mailto:4118006@mul.s.edu.mn">4118006@mul.s.edu.mn</a>
15	Сайханбаяр	ГЗБ-3	90238935 93238935	<a href="mailto:4118049@mul.s.edu.mn">4118049@mul.s.edu.mn</a>
16	Долгорсүрэн	ГЗБ-3	80064801	<a href="mailto:4118008@mul.s.edu.mn">4118008@mul.s.edu.mn</a>
17	Намсрайцэрэн	ГЗБ-3	80991999	<a href="mailto:4118007@mul.s.edu.mn">4118007@mul.s.edu.mn</a>
18	Мөнхдэжид	ГЗБ-3	88333296	<a href="mailto:4118058@mul.s.edu.mn">4118058@mul.s.edu.mn</a>
19	Билгүүн	ГЗБ-4	94117494	<a href="mailto:4114096@mul.s.edu.mn">4114096@mul.s.edu.mn</a>
20	Мөнхжаргал	ГК-4	88947564	<a href="mailto:4817001@mul.s.edu.mn">4817001@mul.s.edu.mn</a>
21	Бямбасүрэн	ГК-4	88688131	<a href="mailto:4817008@mul.s.edu.mn">4817008@mul.s.edu.mn</a>
22	Цэцэглэн	ГҮ-4	80942436	<a href="mailto:4417011@mul.s.edu.mn">4417011@mul.s.edu.mn</a>
23	Янжиндулам	ГҮ-4	86845453	<a href="mailto:4417003@mul.s.edu.mn">4417003@mul.s.edu.mn</a>
24	Ловонбадамжунай	ГЗБ-4	96727295	<a href="mailto:4117042@mul.s.edu.mn">4117042@mul.s.edu.mn</a>
25	Мөнхцэцэг	ГЗБ-4	86558859	<a href="mailto:4417001@mul.s.edu.mn">4417001@mul.s.edu.mn</a>
26	Наранбаатар	ГК-4	90290460	<a href="mailto:4116087@mul.s.edu.mn">4116087@mul.s.edu.mn</a>
27	Аминзул	ГЗБ-4	99240597	<a href="mailto:4117035@mul.s.edu.mn">4117035@mul.s.edu.mn</a>
28	Болортуяа	ГЗБ-4	94381388	<a href="mailto:4117033@mul.s.edu.mn">4117033@mul.s.edu.mn</a>
29	Гомбосүрэн	ГЗБ-4	86700742	<a href="mailto:4117004@mul.s.edu.mn">4117004@mul.s.edu.mn</a>

## III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал	Утас	Цахим хаяг
1	Баянтүмэн	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	Кадастрын хэлтсийн дарга	88056103	<a href="mailto:Bayantumen1229@gmail.com">Bayantumen1229@gmail.com</a>
2	Оюунбаяр	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	Хот байгуулалтын кадастрын хэлтсийн дарга	99743424	<a href="mailto:oyunbayar@gmail.com">oyunbayar@gmail.com</a>
3	Г.Мөнхбаяр	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	Чөлөөлөлтийн хэлтсийн дарга	88860996	<a href="mailto:munkhbayar-nga@gmail.com">munkhbayar-nga@gmail.com</a>
4	Г.Ариунсэлэнгэ	Говь-Алтай аймгийн ГХГЗЗГ	Газрын удирдлагын	99143463	<a href="mailto:selengee39@gmail.com">selengee39@gmail.com</a>

			хэлтэсийн дарга		
5	Э.Чагнаадорж	Дундговь аймгийн ГХБХБГ	Дарга	99101613	<a href="mailto:chagnaaDua@gmail.com">chagnaaDua@gmail.com</a>
6	Ц.Билэгсайхан	Хэнтий аймгийн ГХБХБГ	Хэлтсийн дарга	91910938	<a href="mailto:bilegsaikhan@gmail.com">bilegsaikhan@gmail.com</a>
7	Ш.Наран-Очир	“Вектор map” ХХК	Захирал	89039907	<a href="mailto:sh.naran-ochir@gmail.com">sh.naran-ochir@gmail.com</a>
8	Б.Батчимэг	ХУД-ийн ГЗБ-ын алба	Дарга	99056537	<a href="mailto:Batchimegbat1637@gmail.com">Batchimegbat1637@gmail.com</a>
9	Ц.Ханбүргэд	Геоботаник ХХК	Захирал	91044499	
10	Б.Сайнбаяр	Газрын мэдээлэл ХХК	Захирал	89060279 99060279	<a href="mailto:sainaa_75@gmail.com">sainaa_75@gmail.com</a>
11	Ууганхүү	Гурванхорол ХХК		88893808	<a href="mailto:Gurvankhorol@gmail.com">Gurvankhorol@gmail.com</a>
12	Буянжаргал	Тэнхлэг уул ХХК		96057737	<a href="mailto:B_jargal5@yahoo.com">B_jargal5@yahoo.com</a>
13	Намсрай	Газар дэлхий ХХК		96062166	<a href="mailto:namsrai@gmail.com">namsrai@gmail.com</a>
14	Түмэннаст	Эх монголын байгаль	Захирал	99085806	<a href="mailto:Tumennast@gmail.com">Tumennast@gmail.com</a>
15	Мягмарцэрэн	Ланрес ХХК	Захирал	99119238	<a href="mailto:mega@gmail.com">mega@gmail.com</a>
16	Оюунбилэг	Ланд Мэп ХХК	Захирал	99133000	<a href="mailto:oyunbileg@mail.com">oyunbileg@mail.com</a>
17	Солонго	Нарт ШУУН ХХК	Захирал	99231836	<a href="mailto:solongoG@gmail.com">solongoG@gmail.com</a>
18	И.Эрхбаяр	North map ХХК	Захирал	99090563	
19	Ш.Галам	Георадар ХХК	Захирал	88113635	<a href="mailto:galam@georadar.mn">galam@georadar.mn</a>
20	Отгонжаргал	Архангай ГА	Дарга		<a href="mailto:otgon@gmail.com">otgon@gmail.com</a>
21	Бат-Өлзий	БЗД Газрын алба	Дарга	88114415	<a href="mailto:Ulzii@gmail.com">Ulzii@gmail.com</a>
22	Шинэбаяр	Голден мэп ХХК		99017570	<a href="mailto:goldenmap@gmail.mn">goldenmap@gmail.mn</a>
23	Энхболд	Сүхбаатар аймаг	ГА дарга		<a href="mailto:Enkhbold@gmail.com">Enkhbold@gmail.com</a>
24	Бадам	Газар сервис	Захирал	99006383	<a href="mailto:Badam63t@gmail.com">Badam63t@gmail.com</a>

#### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал	Утас
1	М.Номинзул	2015	Говьсүмбэр аймгийн ГХБХБГ	Геодези зураг зүйн инженер	80000233
2	З.Саранцэцэг	2015	Говьсүмбэр аймгийн засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	80000733
3	С.Уянга	2015	Тайвань улс	Магистрант оюутан	
4	Ц.Энхриймаа	2015	АНУ-д	Магистрант оюутан	
5	Пүрэвдорж	2015	Завхан аймгийн Тосонцэнгэл сум Идэр голын сав газрын захиргаа	Мэргэжилтэн	99008308
6	Б.Болор-Эрдэнэ	2015	Дархан-Уул аймаг ГХБХБГ	Кадастрын мэргэжилтэн	99911291

7	Даваажаргал	2015	Өвөрхангай аймгийн Баруунбаян- Улаан сумын ЗДТГ	Иргэдийн хурлын төлөөлөгч, Төрийн банкны салбарын захирал	99677176
8	Г.Ганхөлөг	2018	Ёлт дата ХХК	Газар зохион байгуулагч	99911615
9	Болд-Эрдэнэ	2015	Говь-Алтай аймгийн ГХБХБГ	мэргэжилтэн	99919268 94386038
10	Б.Эрдэнэбаяр	2016	Дархан-Уул аймаг	Бизнес эрхлэгч	99379759
11	Алтантуяа	2016	Говьсүмбэр аймаг	Хувиараа бизнес эрхлэгч	95154623
12	Мөнх-Ундрал	2017	Зэт би групп ХХК	Газар зохион байгуулагч	99153499
13	Дулам	2017	МАКС групп	Авто замын хяналтын инженер	80041340
14	Сарантуяа	2017	Улаанбаатар	Хувиараа бизнес эрхлэгч	85110597
15	Э.Сувд-Эрдэнэ	2018	Нийслэлийн газар зохион байгуулалтын алба	кадастрын мэргэжилтэн	99190978
16	Д.Пагмадулам	2018	Өмнөговь аймаг ГХБХБГ	кадастрын мэргэжилтэн	89295117
17	Ж.Дэлгэрмаа	2019	Улаанбаатар	Хувиараа бизнес эрхлэгч	95400778
18	О.Зоригт	2020	МГЗБХолбоо	Нарийн бичиг	94112161
19	Батсуурь	2020	Физик технологийн хүрээлэн	эрдэм шинжилгээний ажилтан	
20	Х.Дуламсүрэн	2020	Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ	Газрын даамал	<u>86044499</u>
21	Г.Баянмөнх	2015	ХААИС-АЭС	Сургалтын туслах ажилтан	99956443
22	О.Одбаяр	2016	ХААИС-АЭС	Сургалтын менежер	80020394
23	Дархансайхан	2018	Говь эко ХХК	Газар зохион байгуулагч	89193882
24	Батбаатар	2018	Говьсүмбэр аймгийн ХАА-н газар	мэргэжилтэн	94609028
25	А.Тамираа	2017	Жемир байгаль орчны үнэлгээний компани	Газар зохион байгуулагч	80129037

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ**  
**АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ**

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
11 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 243  
И-мэйл: agroecology@mul.s.edu.mn  
Вэб сайт: www.muls.edu.mn

2021.12.15 № 06/291  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН**  
**ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

**Шинжээчдийн зөвлөмж шаардлагыг**  
**хүлээн зөвшөөрсөн тухай**

Тус сургуулийн “Газар зохион байгуулалт” бакалаврын хөтөлбөр /D053211/-ийг магадлан итгэмжлүүлэхээр 2021 оны 05 дугаар сарын 31-ээс ажилласан шинжээчдийн багийн тайлантай танилцлаа.

Уг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлантай танилцан, сургалтын үйл ажиллагааны оролцогч талуудтай хийсэн ярилцлага, сургалтын орчин, бусад нотлох баримтуудыг үндэслэн шинжээчдийн багийн өгсөн дүгнэлт, зөвлөмж, шаардлагыг хүлээн зөвшөөрч байгааг энэхүү албан бичгээр мэдэгдэж байна.

ЗАХИРАЛ



А.БУЯНБААТАР

**021803271**

## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)  
.....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

1.